- Худгийн гадна талаар нь хамгаалалтын байгууламж барьж, худгийн ойр орчмыг бетондож бохирдол оруулахгүй байх арга хэмжээг авах.
- 2021 оны усны нөөц ашигласны төлбөрийг Налайх дүүргийн Татварын хэлтсийн дансанд 12 дугаар сарын 25-ны дотор төлөх. 1 м³ усны төлбөр 198.24 төг.
- Тоолуурын заалтын баталгаа алдагдсан, шугам хоолойгоос салгасан тохиолдолд усны нөөц ашигласны төлбөрийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцож оногдуулахыг анхаарах.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хэмнэлттэй байдлаар ашиглах шаардлагын хүрээнд ариун цэврийн өрөө, шүршүүрт мэдрэгчтэй төхөөрөмж суурилуулж усыг хэмнэх.
- Бага оврын цэвэрлэх байгууламжтай болох, цэвэрлэгдээд гарсан усыг ногоон байгууламж, зам талбайн усалгаа, ариун цэврийн байгууламжид хэрэглэх боломжийг бүрдүүлж ажиллах.
- Хур бороо цас мөсний усыг хуримтлуулж ногоон байгууламж, зам талбайн усалгаанд хэрэглэх.
- Байгууллагын хашаанд мод тарих, зүлэгжүүлэх ажлыг зохион байгуулах.
- Жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тухай оны ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж байх.

Хувийг: Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Татварын хэлтэст

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.НЯМБАЯР

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 10 дугаар сарын 26 өдөр

Дугаар 2022/08

Налайх дүүрэг

Нэг. Ерөнхий зүйл

Нийслэлийн Байгаль орчны газрын даргын олгосон 2021 оны 10 дугаар сарын 07-ний өдрийн 2021/39 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Налайх дүүргийн Засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/328 дугаар захирамжийг үндэслэн: **Ус ашиглуулагчийг төлөөлж:** Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Ц.Тунгалаг, **Ус ашиглагчийг төлөөлж:** Налайх дүүргийн 6 дугаар хорооны Өвөр хүүшийн аманд байрлах 9019087070 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 5235545 регистрийн дугаартай “ДНДХ” ХХК-ийн “Тэрэлж стар” жуулчны баазын захирал С.Амгаланбат нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг дуустал 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл:

2.1. **Ус ашиглах зориулалт:** Аялал жуулчлалын чиглэлээр иргэдэд үйлчилгээ үзүүлэхэд унд, ахуйн хэрэгцээнд ашиглана.

2.2. **Ашиглах усны хэмжээ:**

- 2.2.1. Унд- ахуй, м³/жил..... 1511.1 м³.....
- 2.2.2. үйлдвэрлэл, үйлчилгээ м³/ жил 11563.2 м³.....
- 2.2.3. Зүлэг талбайн усалгаа м³/ жил м³
- 2.2.4. эмчилгээ, сувилгаа, хүн/ хоног-.....

2.3. **Усны чанар, найрлага:**

2.4. Усны эх үүсвэрийн :

Байршил: Налайх дүүрэг 6 дугаар хороо Өвөр хүүшийн ам

Солбилцол: 47°51'48.69"N, 107°26'47.87"E;

Барилга байгууламж: Унд ахуйн, үйлчилгээний зориулалтаар гаргасан гүний худгаас өөр барилга байгууламж байхгүй. Цэвэр усны нөөцийн сав 4 м³

Тоног төхөөрөмжийн нэр, марк: Худагт 70 м гүнд QJD маркийн усны насос суурилуулсан.

Хүчин чадал: 80м өрөмдөж гаргасан 1 худагтай. Ундаргаар нь тооцоход хоногт 84.6 м³ ус авч ашиглах боломжтой, амралтын газар нь хоногт 40.0 м³ ус ашигладаг.

Хэмжээ:

Стандартын шаардлага:

Хаях цэгийн байршил:

Солбилцол:

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг

Органик бодис, кг

Эрдэс бодис, кг

Хүнд метал, кг

Аюултай бохирдуулах бодис, бодис, гр

2.7 **Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:** 10 м³ багтаамжтай бетонон доторлогоотой бохирын цооногт бохирыг хуримтлуулж зөөдөг.

2.8. **Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:** Зарцуулдаггүй.

2.9. **Усны тоолуурын:** Төрөл, нэр, дугаар:

Загвар: LXLG загварын 32 мм голчтой усны тоолууртай.

Тоолуурын тоо: 2019 оны 5 дугаар сард худгийн гаргалгааны шугам дээр 1 тоолуур суурилуулсан. 2021 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр баталгаажуулсан.

Байгаль орчны үнэлгээ, огноо: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг “Экомастер” ХХК-иар хийлгэсэн.

Тоолуурын заалт: 04769м3.....

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ: 2019 оны ус ашиглах дүгнэлтээр ажилтан албан хаагчдын унд ахуйд 1511.1 м3, Үйлчилгээний зориулалтаар 11563.2 м3, **нийт 13074.3 м3** ус ашиглах тооцоо гарсан бөгөөд усны төлбөрийг “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын засгийн газрын 327 дугаар тогтоолын дагуу усны төлбөрийг усны тоолуурын заалтаар 2022 оны 12 дугаар сарын 25-ны дотор Налайх дүүргийн Татварын хэлтсийн **Хаан банкны 5749922224** дугаартай дансанд төвлөрүүлнэ.

2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:-.....

Гурав. Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2 аль нэг тал татан буугдсан бол.

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Ус ашиглуулагчийг төлөөлж:


Налайх дүүргийн

Засаг даргын орлогч

 С. Тунгалаг

Ус ашиглагчийг төлөөлж:

“ДНДХ” ХХК-ийн /“Тэрэлж
стар” жуулчны бааз/ захирал

 С.Амгаланбат-Э





**НИЙСЛЭЛИЙН
НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/Б28

Улаанбаатар хот

Ус ашиглах зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Усны тухай (шинэчилсэн найруулга) хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5, 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “ДНДХ” ХХК-ийн “Тэрэлж стар” жуулчны бааз (С.Амгаланбат)-д үйлчилгээний зориулалтаар ус ашиглах зөвшөөрлийг олгосугай.

2. Ус ашиглахад тавигдах шаардлагуудыг биелүүлэн, ус авах цэгт тоолуур байрлуулж, гэрээ байгуулж ажиллахыг “ДНДХ” ХХК-ийн “Тэрэлж стар” жуулчны бааз (С.Амгаланбат)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хот төлөвлөлт, үйлдвэрлэл, ногоон хөгжлийн чиглэлийн төсөл хөтөлбөрийн удирдагч бөгөөд Засаг даргын орлогч С.Тунгалагт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.РАДНААБАЗАР

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Хянан баталгааны төрөл: Захиалгат

Огноо: 2020.01.28

1. Газар ашиглагч: ДНДХ
2. Аймаг (нийслэл): Улаанбаатар Сум (дүүрэг): Налайх
3. Байршил, хаяг: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 6-р хороо
4. Нэгж талбарын дугаар:
5. Хөрсний нэр: 1214, Уулын ойн ширэгт бараан хөрс
6. Ургамалжилт: УХ-II-2-8 Жижиг дэгнүүлт үетэнт- алаг өвст
7. Нийт талбайн хэмжээ: 5.5 га
8. Газар эзэмших зориулалт: Аялал жуулчлал
9. Одоогийн газар ашиглалтын хэлбэр: Жуулчны бааз
10. Газар ашиглах, эзэмших шийдвэр: БОНХЯ-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын 2018 оны тушаал
11. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 0171062
12. Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт:

Эзэмшил газрын ангилал		Талбай, м ²	Үүнээс эвдэрч бохирдсон, талбайн хэмжээ, м ²		
			Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшлийн газар		55000.5	-	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай		55000.5	-	-	-
А.Зөвшөөрөлтэй ашиглаж байгаа талбай		55000.5	-	-	-
1. Үйл ажиллагаанд өртөөгүй талбай		47454.19			
2. Үйл ажиллагаанд өртсөн талбай		7546.31	-	-	-
Үүнээс	Хүлээн авах болон дэлгүүр	616	-	-	-
	Гэр ресторан	230	-	-	-
	Гэр бааз байгуулсан талбай	6700	-	-	-
	Авто зам	170	-	-	-
	Явган хүний зам	140	-	-	-

13. Газрын гадарга, төлөв байдал:

Энэхүү нэгж талбарт жуулчны бааз байгуулан улирлын чанартай ажиллаж байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт 7546.31 м² талбайг дундаас хүчтэй зэрэг эвдрэлд өртсөн байна.

14. Хөрсний доройтол, бохирдолт, түүний төрөл, зэрэглэл:

Уг нэгж талбарт уулын ойн ширэгт бараан хөрс тархсан байна. Тус нэгж талбарын хөрснөөс авсан хөрсний шинжилгээний дүнг доор үзүүлэв.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээж №	Дээж авсан гүн, см	Жижиг хэсгийн эзлэх хэмжээ мм, хувиар							
		Элс			Тоос				Шавар
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
Дээж-1	-	23.0	39.2	18.9	8.7	6.1	4.2	18.9	

Хөрсний шинжилгээний дүнгээр физик шаврын хэмжээ элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй.

Хөрсний химийн шинж чанар

Зүсэлт	Гүн, см	pH H ₂ O	ЦДЧ, dS/m	Давс	Ялз маг %	CO ₂	Солилцох суурь, мг-экв/100 гр			Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
							Ca+Mg	Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O



Дээж-1	-	7.8	0.470	0.23	3.87	0.0	28.2	17.1	11.1	3.5	21
--------	---	-----	-------	------	------	-----	------	------	------	-----	----

Хөрсний үржил шимийн түвшин буюу ургамалд ашигтай хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжтай. Хялбар уусах давсны агууламж маш бага байна. Ялзмагийн агууламж хэвийн, карбонатгүй байна. Шингээгдсэн сууриудын нийлбэр хэмжээ хэвийн, хөрсний урвалын орчин сул шүлтлэг байна.

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж мг/кг					
	Ni /никель/	Cd /кадмий/	Pb /Хар тугалга/	Zn /цайр/	Cr /хром/	Cu /зэс/
0	23.6	ND	18.5	44.1	ND	19.2
Хүлцэх агууламж /MNS 5850:2008/	60.0	1.0	50.0	100.0	60.0	60.0
Хортой агууламж /MNS 5850:2008/	1000.0	10.0	500.0	600.0	400.0	500.0
Аюултай агууламж /MNS 5850:2008/	1800.0	20.0	1200.0	1000.0	1500.0	1000.0

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж үзэхэд стандартын хүлцэх агууламж болон хортой, аюултай агууламжаас бага байна.

15. Ургамлын нөмрөгийн төрх байдал, доройтлын зэрэглэл:

Төслийн талбайн районд жижиг дэгнүүлт үетэнт-алаг өвст бэлчээрийн хэв шинжтэй бүлгэмдэл тархсан байна. Бүлгэмдлийн ноёлогч нь сунагар биелэг (*Poa attenuata*) байна. Үетний зүйлийн бүрхцийн оролцоо өндөр (*Agropyron cristatum*), (*Cleistogenes squarrosa*), (*Stipa krylovii*) дэд зонхилогчоор ургана. Алаг өвснөөс (*Artemisia dracunculus*), (*Astragalus vericolor*), (*Craniospermum canescens*), (*Polygonum angustifolium*), (*Potentilla acaulis*) зэрэг ургадаг байна.

16. Газар ашиглалтын зөрчил, аюулгүй байдал:

Тус төслийн талбай нь орчны бохирдол байхгүй, газар ашиглалтын аюулгүй байдал зөрчигдөөгүй байна.



17. Газар ашиглалтын талаар цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

Тухайн нэгж талбарын хөрс төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр байгалийн унаган төрх бага зэрэг өөрчлөлтөнд орж байгаа гэж дүгнэж болно. Цаашид төсөл хэрэгжүүлэгч нь амралтын бүх төрлийн үйлчилгээг байгаль орчинд ээлтэй байдлаар төлөвлөх, аялал жуулчлалын үйл ажиллагааг явуулахдаа байгалийн унаган төрхийг хадгалах хамгаалах, хүрээлэн буй орчин, биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах талаар арга хэмжээний төлөвлөгөөтэй ажиллах шаардлагатай.

MNS 6426:2013 “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц, Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Монгол Улсын стандартын дагуу үйл ажиллагаагаа төлөвлөх хэрэгтэй.

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА БӨГӨӨД
УЛСЫН ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

А.БАТБАЯР





Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2021 оны 07-дугаар сарын 07-ны өдрийн
А/154 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДҮГНЭЛТ

Дугаар **0005920**

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр: **"ДНДХ" ХХК**

Хаяг: **НАЛАЙХ ДҮҮРГИЙН 6 ДУГААР ХОРОО ӨВӨР ХҮҮШИЙН АМ**

Ажлын байрны зориулалт, үйл ажиллагааны чиглэл:

ЖУУЛЧНЫ БААЗ

Барилга байгууламжид гал унтраах тоног төхөөрөмж, /гал унтраах автомат болон дохиоллын систем, утаа зайлуулах систем, усан хангамж/ анхан шатны багаж хэрэгсэл, бодис материал зэргийг байрлуулан ашиглахад энэхүү дүгнэлтийг олгоно.

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3/

Олгосон **2022** он **10** сар **24** өдөр

Хүчинтэй хугацаа **2025** он **10** сар **24** өдөр хүртэл

Дүгнэлт олгосон:

НАЛАЙХ ДҮҮРГИЙН аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
дарга **ХУРАНДАА** цолтой **Л. ЧИНБАТ**

Дүгнэлт гаргасан:

НАЛАЙХ ДҮҮРГИЙН аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар /хэлтсийн/
Гал түймрийн улсын хяналтын байцаагч **АХМАД** цолтой **Г. ХАШЧУЛУУН**

/тэмдэг дарна/





“ДНДХ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ
С.АМГАЛАНБАТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2022.10.25 № 13/623Ф
танай _____-ны № _____-т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**

Танай байгууллагаас боловсруулж ирүүлсэн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хязгааралтын бүс “Өвөр хүүшийн” аманд хэрэгжүүлж буй аялал жуучлалын баазын нэмэлт тодотголын төсөлд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, “Журам батлах тухай” Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд батлагдсан аргачлалын хүрээнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2023 оны 1 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт ... хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Г.ЭНХМӨНХ



**ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСЭЛТ, БАРИМТ БИЧИГ
ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ**


Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: ДНДХ ХХК, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, жуулчин Урт цагаан В корпус.

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 976-99115376, 86845453

Төслийн нэр: Аялал жуулчлалын бааз

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Горхи-Тэрэлжийн БЦГ-н хязгаарлалтын бүс
Өвөр хүүшийн аманд хэрэгжинэ.

Баримт бичгийн нэр	Шаардлагатай эсэх	Шаардлага хангасан эсэх	Тайлбар
Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/	Тийм	+	
Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөл	Тийм	+	Батлагдсан зураг төсөл шаардлагатай.
Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан эсэх /газрын зөвшөөрөл, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал/	Тийм	+	БОАЖС-ын 2018 оны 05 дугаар сарын 01-ны А/114 дугаар тушаал. БОАЖЯ-ны ТХБНУГ-ын даргаас 2018 оны 05 сарын 07-ний өдөр олгосон газар ашиглах гэрчилгээтэй №0171062.ГТБЦГХамгаалалтын захиргааны 2022 оны 08 сарын 29-ний өдрийн 22/580 тоот санал.
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	Үгүй		
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан	Тийм	+	Төгрөг баян хангай ХХК
Төсөл хэрэгжих орчны тойм зураг (топо, сансрын)	Тийм	+	
Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт	Үгүй		
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/	Тийм	+	
<p>Тусгай тэмдэглэл: ДНДХ ХХКомпанийн аялал жуулчлалын баазын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын “Аргачлал батлах тухай” 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу хийлгэх шаардлагатай гэж үзлээ.</p>			
<p>Ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт, материалыг хянасан: БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ШИНЖЭЭЧ</p>			



Б.БАТБАЯР

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХУУДАС**

Улаанбаатар хот

2022 оны 10-р сарын 07

Төслийн дугаар

Дугаар 2022/Б-57

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: ДНДХ ХХК, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, жуулчин Урт цагаан В корпус.

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 976-99115376, 86845453

Төслийн нэр: Аялал жуулчлалын бааз

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Горхи-Тэрэлжийн БЦГ-н хязгаарлалтын бүс
Өвөр хүүшийн аманд хэрэгжинэ.

Газрын солбилцол:

№	Х	Ү
1	107 26 52.325	47 51 43.173
2	107 26 48.403	47 51 46.552
3	107 26 43.686	47 51 44.718
4	107 26 41.280	47 51 47.520
5	107 26 49.490	47 51 50.403
6	107 26 52.015	47 51 47.957
7	107 26 54.182	47 51 48.173
8	107 26 50.155	47 51 51.389
9	107 26 53.520	47 51 54.000
10	107 27 00.900	47 51 47.337
11	107 26 58.764	47 51 44.784
12	107 26 55.673	47 51 47.028
13	107 26 52.593	47 51 46.474
14	107 26 54.222	47 51 43.752
5.5 га		

Орон нутгийн санал: БОАЖС-ын 2018 оны 05 дугаар сарын 01-ны А/114 дугаар тушаал. БОАЖЯ-ны ТХБНУГ-ын даргаас 2018 оны 05 сарын 07-ний өдөр олгосон газар ашиглах гэрчилгээтэй №0171062.ГТБЦГХамгаалалтын захиргааны 2022 оны 08 сарын 29-ний өдрийн 22/580 тоот санал. Мөн компаниас цахим систем болох и-монголиа-р ирүүлсэн 099-2209-000301 дугаартай хүсэлтийг үндэслэв.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл, тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт	Тийм			Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох

Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	Тийм			Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)	Тийм			Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх			Тийм	
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	<ol style="list-style-type: none"> 1. Төслийн явцад орчны бохирдлыг тооцож, үйл ажиллагаанаас агаарт үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлох, 2. Төслийн үйл ажиллагаанаас гарах хатуу, шингэн хог хаягдлын байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тогтоож, арилгах, бууруулах, байгаль орчинд халгүй аргаар зайлуулах арга хэмжээг төлөвлөх, 				
	Усан орчин				

Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	
Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	
<ol style="list-style-type: none"> Газрын доорхи болон гадаргын усны нөхцөл байдлыг тодорхойлж, төслийн үйл ажиллагааны явцад ашиглах усны эх үүсвэр, хэмжээг тодорхойлж, түүнтэй уялдуулан нарийвчилан тооцох; Төслийн үйл ажиллагаанаас усны нөөц, горим чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоож, түүнд тавих хяналт, хугацаа, хөрөнгө зардлыг нарийвчилан тооцох; Усны алдагдлыг багасгах, усыг хэмнэлттэй ашиглах технологийн хувилбарыг судалж, тайланд тусгах; Ахуйн бохир усны хэмжээ, найрлагыг нарийвчилан тогтоож, түүнийг байгаль орчинд халгүйгээр зайлуулах арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг тооцох; Усны тухай хууль, тогтоомж болон бусад хууль тогтоомжоор хориглосон хязгаарласан бүсийн дэглэмийг зөрчихгүй байх талаар зөвлөмж боловсруулж тайланд хавсаргах; 				
Хөрсөн бүрхэвч				
Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
<ol style="list-style-type: none"> Төслийн үйл ажиллагааны явцад хөрс, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг багасгах, арилгах, цөлжилт, хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх арга зам, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх; Хатуу, шингэн хог хаягдал, техник технологийн ашиглалтын явцад хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх; Олон салаа зам гаргах, хөрс бохирдох, эвдрэхээс сэргийлэх, тогтсон нэг орц, гарцыг тогтоох; Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх төлөвлөгөөг холбогдох зураг төслийн хамт боловсруулж, тайланд хавсаргах; 				
Ургамлан нөмрөг				
Ургамлан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	Ургамлан нөмрөг өртөнө.
Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	Нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлох
<ol style="list-style-type: none"> Төслийн үйл ажиллагаа явуулахад өртөх талбайн ургамлын нэр төрөл, тархалтыг тогтоох, ховор болон нэн ховор ургамал байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж, хэрэв тэдгээр нь төслийн үйл ажиллагааны явцад өртөхөөр байвал түүнийг хамгаалах, болон шилжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгө зардлыг төлөвлөх; Эдэлбэр газар, орчныг тохижуулах, ногоон байгууламж байгуулах талаар мэргэжлийн түвшний зөвлөмжийг шаардагдах зардлын хамт боловсруулж, тайланд тусгах; 				

	3. Төслийн үйл ажиллагааны улмаас сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүнийг нарийвчилан тогтоож, хамгаалах арга замыг цогц байдлаар шийдэхэд заавар, зөвөлгөө өгөх, тайланд тусгах;				
	Амьтны аймаг				
	Зэрлэг амьдрах доройтуулах, эсэх	амьтдын орчинг			Тийм
	Ховор, амьтан өртөх, эсэх	нэн ховор			Тийм
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид				
	Газар ашиглах эрх зөрчигдөх, эсэх	эзэмших,	Тийм		
	Нутгийн суугчдын байдалд нөлөөлөлтэй, эсэх	оршин нийгмийн сөрөг			Тийм
	Нөлөөлөлд болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх	өртөж			Тийм
	Нүүлгэн асуудал үүсэх, эсэх	шилжүүлэх			Тийм
	1. Нарийвчилсан үнэлгээ хийх явцад тухайн газрыг хариуцан хамгаалж буй хамгаалалтын захиргаанд төслөө танилцуулж, санал авч тайланд хавсаргах;				
	Түүх, соёлын биет өв				
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх				Тийм
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх				Тийм
Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх				Тийм	
	1. Төслийн үйл ажиллагаа болон байгалийн гамшгаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээ хийж, ослоос сэргийлэх, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлж тайланд тусгана.				
Нэгдсэн дүгнэлт: Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын “Аргачлал батлах тухай” 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу хийлгэн, нарийвчилсан үнэлгээний тайланг тус яаманд 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлж, шүүмж хийлгэн, шийдвэр гаргуулах шаардлагатай гэж үзлээ.					

Онцгойлон анхаарах зүйлс:

- 1. БОАЖЯамны ТХБНУГ-т төслийг танилцуулан санал авч, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг батлагдсан аргачилалын дагуу боловсруулах;**
- 2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл...”-ийг бүрдүүлнэ гэсний дагуу зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж төрийн эрх бүхий байгууллагаар баталгаажуулан БОННУ-нд хавсаргах;**
- 3. Төслийг “Тусгай хамгаалалттай газар нутаг дахь, эко аялал жуулчлалын зориулалттай байр, сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6426:2013 стандартын шаардлага хангуулах, талаар зөвлөмж боловсруулж тайланд хавсаргах;**
- 4. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын бүсийн дэглэмийн дагуу үйл ажиллагаа явуулах, 12 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх;**
- 5. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 5 жилээр боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг төслийн хүчин чадал, төслийн үйл ажиллагааны өрнөлтийн байдалтай уялдуулан тооцож, төлөвлөх;**
- 6. Аяллын хөтөлбөр, маршрут нь байгаль хамгааллыг зорилго, байгалийн үнэт зүйлсийг хамгаалах үндсэн чиглэлтэй хэрхэн уялдаж байгаад дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулах;**
- 7. Гэрээгээр ашиглах газрын хариуцан хамгаалах орчныг тохижуулж, зүлэгжүүлэх, ногоон байгууламж байгуулах төсөл, боловсруулж хэрэгжүүлэх;**
- 8. “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийх асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах;**
- 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг нарийвчлан гаргах;**
- 10. Усны хэрэглээний хэмжээг эх үүсвэртэй уялдуулан түүнээс гарах бохир усыг тус тус нарийвчилан тооцох;**
- 11. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн газрын гүний усны судалгаа, нөлөөллийг тогтоох;**
- 12. Хог хаягдлын менежментийн асуудлыг бүлэг болгон байгаль орчинд халгүйгээр зайлуулах аргыг нарийвчилан тодорхойлох;**
- 13. Амралт сувилалын газрын үйлчилгээ MNS 4958:2000, Аялал жуулчлалын байр сууцны төрөл үндсэн шаардлага MNS 5824:2007, Амралтын газар, жуулчны бааз гэр буудалд тавих ерөнхий шаардлага MNS 6043:2009, Жуулчны баазын үйлчилгээ чанарын зэрэглэл үндсэн, шаардлага MNS 4934:2002 стандартуудыг мөрдөж ажиллах зөвлөмж боловсруулах;**
- 14. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 156 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас ургамал, хөрс, амьтан, агаар орчинд учруулах хохирлыг байгалийн бүрэлдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар учирч болох хохирлыг урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган төслийг хэрэгжүүлэх байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодруулж дүгнэлт гаргах;**
- 15. Төслийн үйл ажиллагааны явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажиллагсадын эрүүл мэнд, ажлын байрны эрүүл ахуйн талаар зөвлөмж, дүгнэлт боловсруулах;**
- 16. Тооцоо нийлсэн акт, гурвалсан гэрээ дүгнэсэн актыг хавсаргах, ой ус, тусгай хамгаалалттай газрын кадастрын хэлтэсээс лавлагааг аван хавсаргах, БОМТ-ны хэрэгжилт.**

17. Төслийн хүрээнд баригдах дэд бүтцийн барилга, байгууламжийн батлагдсан зураг төслийг тайланд хавсаргах бөгөөд ариун цэврийн байгууламжийн шийдлийг зайлшгүй тусгах шаардлагатай ба халаалтын асуудлыг байгаль орчинд ээлтэй аргаар шийдвэрлүүэн тусгах шаардлагатай;
18. Төсөл хэрэгжих тухайн бүс нутагт ТХГНутгийн тухай хуулинд зааснаас өөр зориулалтаар газрыг ашиглахгүй байх;

Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн дагуу хариуцлага тооцохыг урьдчилан мэдэгдье.

Бусад зүйлс:

1. Төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны хяналтын байгууллага, Хамгаалалтын захиргаанаас тавигдах нэмэлт шаардлагыг цаг тухай бүрт нь ханган биелүүлж байх;
2. Байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөц баялгийг зохистой ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг биелүүлэх талаар байгаль орчин, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай байнга хамтран ажиллах;
3. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх;
4. Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, нөхцөл, болзлоос өөр үйл ажиллагаа явуулах болон төсөлд өөрчлөлт орох, эсхүл өргөтгөх, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх бүрт Ерөнхий үнэлгээнд хамрагдаж байх;

Ерөнхий үнэлгээ хийсэн:

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээч

Б. Батбаяр

Б.БАТБАЯР

Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:
“ДНДХ” ХХКомпанийн захирал



С.АМГАЛАНБАТ

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2022 оны 10 сарын 26 өдөр

Дугаар ...

Налайх дүүрэг

Гэрээний зорилго: Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад "Хөдөлмөрийн тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай", "Аялал жуулчлалын тухай", "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай", "Хог хаягдлын тухай", "Зөрчлийн тухай" "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай", "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай" хууль холбогдох дүрэм, журам, дүүргийн удирдлагаас гарсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, төр захиргааны эрх бүхий байгууллагаас дэмжлэг үзүүлэн, хяналт тавих, нөгөө талаас сайн дурын үндсэн дээр орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийн хүрээнд нийгмийн хариуцлагыг тодорхойлж, хамтран ажиллахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Нэг. Ерөнхий зүйл

Нэг талаас Дүүргийн удирдлагыг төлөөлж Налайх дүүргийн Засаг даргын орлогч С.Тунгалаг (цаашид "Захиргааны байгууллага" гэх), нөгөө талаас Аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөж Налайх дүүргийн хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа регистрийн дугаартай, "....." ХХК-ийн захирал (цаашид "ААН, байгууллага" гэх) нар нь хамтран дараах нөхцлүүдийг хэлэлцэн тохиролцож, харилцан зөвшөөрснөөр энэхүү гэрээг байгуулав.

1.1. Талууд бие биенийхээ үйл ажиллагааг харилцан хүндэтгэж, гэрээний заалтуудыг чанд мөрдөнө.

1.2. Гэрээг 2% үйлдэж, хоёр тал харилцан тохиролцон гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талуудад гэрээний 1 хувийг хадгалуулна.

1.3. Гэрээ нь 2022 оны 10-р сарын 26-ний өдрөөс 2023 оны 10-р сарын 26-ний өдөр хүртэл 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

1.4. Аль нэг талын санаачлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

Хоёр. Нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

2.1. Хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчлах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлнэ.

2.2. Газар ашиглах, эзэмших үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжинд заасан үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, гарсан зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах.

2.3. Захиргааны байгууллага нь гэрээний хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн аливаа үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд тухай бүр нь үнэн зөв мэдээлж ажиллах

2.4. Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч сургалт, семинар, үзэсгэлэн худалдаа болон бусад арга хэмжээнд оролцуулах ажлыг зохион байгуулах

Гурав. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

3.1. Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийг чанд биелүүлж, олон нийтийг хамарсан арга хэмжээ болон нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхи санаачлагатай оролцох

3.2. Аж ахуйн нэгж, байгууллага нь орчны 50м хүртэлх газрын ашиглалт хамгаалалт, цэвэрлэгээ, халтиргаа, гулгааг хариуцан тогтмол цэвэрлэх, мод, бут, зүлэг тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны тохижилтод хувь нэмрээ оруулж, гаднах хаягаа гэрэлтдэг, товгор крилл үсгээр бичиж байршуулах, гэрэлтүүлгийг стандартын дагуу хийж гүйцэтгэх, хог хаягдлын гэрээ байгуулан ажиллах

3.3. Нийслэлийн агаарын бохирдлыг багасгах зорилтын хүрээнд өвлийн улиралд сэргээгдэх эрчим хүчний бие даасан үүсгүүр, стандартын шаардлага хангасан хийн болон цахилгаан халаагуур, бүрэн шаталттай шахмал түлш ашиглах

3.4. Зориулалтын (2-3 хоногийн багтаамжтай) хогийн савтай байж, бохир усны цооног, бие засах газрыг стандартын шаардлага хангасан хөрс бохирдуулахгүй байдлаар шийдэх

3.5. Орон нутгийн нийгмийн халамж дэмжлэг шаардлагатай өрх, иргэдэд чиглэсэн тодорхой үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх

3.6. Дүүрэгт ажлын байрыг нэмэгдүүлж, ажиллах хүчний 80 хүртэлх хувьд дүүргийн харьяалалтай иргэдийг хамруулж, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулан, чадваржуулах ажлыг зохион байгуулж, ажиллагсдын хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл болон, тухайн дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг эн тэргүүнд тавьж, ажлын байран дахь аюул

эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтантай мэдээлэл солилцож, хамтран ажиллах

3.8. Ажилчдыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалд хуулийн дагуу цаг хугацаанд нь хамруулах

3.9. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. /Хөдөлмөрийн сайдын 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн №36 дугаар тушаалаар батлагдсан/

Дөрөв. Гэрээ дуусгавар болох

Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд

4.1. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах талаар аль нэг тал нөгөө талдаа бичгээр мэдэгдсэн боловч нөгөө тал нь ажлын 14 хоногт багтаан асуудлыг шийдвэрлээгүй эсхүл хариу өгөөгүй тохиолдолд;

4.2. Гэрээний хугацаа дуусаж, цаашид сунгагдахгүй болсон.

4.3. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг сунгахгүй.

4.4. Давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг, халдварт өвчний тархалт, дайн байлдаан, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, нийтийг хамарсан ажил хаялт, эрх бүхий байгууллагаас гаргасан хорио цээр гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээг хүчингүйд тооцно.

Тав. Нэмэлт нөхцөл

1,500,000 Тогроогийн хандив өгнө
(сүүтэй)

Зургаа. Гэрээний хариуцлага, дүгнэх

6.1. Талууд гэрээний биелэлтэд тавих хяналтыг хамтран хийж, оны эцэст үр дүнг тооцож гэрээг дүгнэнэ.

6.2. Дүүргийн ойн арга хэмжээ болон дүүргийн хөгжилд оруулах хөрөнгө оруулалтын ажлуудыг талууд харилцан зөвшилцөж, тухай бүрт нь шийдвэрлэн хамтран ажиллана.

6.3. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Удсын "Зөрчлийн тухай", "Хог хаягдлын тухай", "Байгаль орчныг хамгаалах тухай" болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.4. Холбогдох хууль тогтоомж, стандарт, гэрээгээр хүлээсэн үүргээ давтан зөрчсөн, иргэдийн эрх ашгийг ноцтой хохироосон нь тогтоогдсон нөхцөлд аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг холбогдох хуулийн байгууллагатай хамтран бүрэн зогсоох арга хэмжээ авна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ДҮҮРГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

С.ТУНГАЛАГ

2022 оны 10 сарын 26 өдөр

ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТУНГАЛАГ

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

"ДНДХ" ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

М.С.Амгаланбаатар

2022 оны 10 сарын 26 өдөр

УТАС:

"ДНДХ" ХХК-ИЙН

АЖИЛТАЙ

М.С.Амгаланбаатар

2022 оны 10 сарын 26 өдөр

УТАС



БАТЛАВ
 НАЛАЙХ ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ
 ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
 ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
 Д.НАЯНБАЯР

БАТЛАВ

Тэрэнсэр
 Мөнхсэр
 БРД:
 ДИХ ХХК
 1118259928
 УЛААНБААТАР ХОТ

ХОГ ХАЯГДЛЫГ АЧИЖ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

20...оны...сарын...өдөр

№ 2206078

Налайх дүүрэг

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ЗОРИЛТ: Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх харилцааг зохицуулах, аж ахуйн нэгж байгууллага, ХХЭрхлэгч нэг бүрийн үүрэг хариуцлагыг тодорхойлж дүгнэх, Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Нийслэлийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор батлагдсан “Хот тохижилт, цэвэрлэгээний талаар албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дагаж мөрдөх журам”, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Нийслэлийн ИТХ-ийн 2012 оны 61-р тогтоол, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөнчийн Хурлын 2021 оны 07/02 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү гэрээг нэг талаас “Тохижилт Үйлчилгээ” ОНӨААТҮГ-ыг төлөөлж, *С.Солонгой* ААН-ийг төлөөлж *Салх.Н.Балд* бид харилцан тохиролцож 2022 оны 06 сарын 30-ны өдрөөс жилийн хугацаатай байгуулав.

НЭГ: “ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ” ОНӨААТҮГ-ЫН ЭРХ ҮҮРЭГ

1. Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн сар бүр тогтмол өөрийн тээврийн хэрэгслэлээр түрж булах.
2. Хог тээвэрлэлтийн талаарх санал гомдлыг хүлээн авч тухай бүр нь шуурхай шийдвэрлэж байх.
3. Хог хаягдлын төлбөрийн төсөвт төвлөрүүлсэн даруйд хөнгөн шуурхай үйлчилж тогтоосон хугацаанд хогийг тогтмол дарж устгаж байх.

ХОЁР: ГЭРЭЭТ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЭРХ ҮҮРЭГ.

1. Хог хаягдлыг агуулах тусгай тагтай савтай байх, хогоо хогийн цэгт заасан байршилд гаргаж асгаж байх, ил задгай асгах шатаах зэргээр орчин бохирдуулахгүй байх.
2. Дүүргийн ЗДТГ-аас хариуцуулсан болон өөрийн орчны газрынхаа хог хаягдлыг байнга цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийн ажилд оролцож байх.
3. Хог тээвэрлэлтийн талаарх санал гомдлоо холбогдох байгууллагуудад гаргаж шийдвэрлүүлэх.

ГУРАВ: ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

1. Хог тээврийн дундаж км 1 удаагийн ачилтын үнэ нийт байна. Гэрээний хугацаанд энгийн хог хаягдлыг 30 хоногт удаа байна. Нэмэлтээр ачуулсан тохиолдолд нэмэгдэл төлбөрийг төлнө.
2. Үйлдвэрийн гаралтай (аюултай хог хаягдал, барилга, малын гаралтай) хог хаягдлыг тусгай зориулалтын хог тээврийн авто машинаар нэмэлт төлбөрөөр ачиж тээвэрлэнэ.
3. Хог хаягдлын тухай хуулийн 10.2.3. дахь заалтын дагуу хог хаягдал гаргасан төлбөр төгрөгийг удаа бэлэн бусаар Налайх Тохижилт үйлчилгээ

С.Солонгой

ОНӨААТҮГ-ын ХААН банк 5749062084 тоот дансанд “Хог түрэлтийн хураамж” тушааж мөнгө тушаасан баримтыг үндэслэн хог хаягдлыг тээвэрлэнэ.

ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

1. Хог тээврийн гэрээ байгуулахгүй, зориулалтын бус газар хог хаягдал хаясан аж ахуйн нэгж, байгууллагыг Хог хаягдлын тухай хуулийн 22.4.2 дугаар заалтын дагуу 150000-250000 төгрөгөөр торгоно.
2. Эрүүл ахуйн тухай хуулийн 22.1.2-т зааснаар энэ хуулийн 4.3.1, 4.3.2, 4.4.1, 4.4.2, 5.2, 5.3, 6.2, 7.1, 7.4, 8.2, 20.1.2, 20.1.3-т заасныг зөрчсөн бол хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, албан тушаалтныг Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр, хуулийн этгээдийг хоёр сая төгрөгөөс гурван сая төгрөгөөр хяналтын байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч торгож, үйл ажиллагааг нь зогсоох 22.2-д зааснаар Энэ хуулийн 4.4.3, 4.4.4-т заасныг зөрчсөн бол хүнийг хоёр зуун мянган төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сая төгрөгөөс хоёр сая төгрөгөөр сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга торгох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ГЭРЭЭ ХИЙСЭН

НАЛАЙХ	ТОХИЖИЛТ	ҮЙЛЧИЛГЭЭ	ТӨЛӨӨЛЖ
ОНӨААТҮГ-ЫГ ТӨЛӨӨЛЖ			Менеджер
965612561		1	В. Саяидмалт
			94104210
СОЧИН ГЭУЭЛ			